ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 18 өдөр Дугаар А/61 Төмөрбулаг сум

Хорио цээр тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59- дүгээр зүйлийн 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тум тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын Бүгсийн нуруу дагуу ойн сангийн 60,62,73,87,90,106 хэсэглэлүүдийн ойн талбайд якобосны төөлүүрч, шилмүүсний хуйлагч эрвээхэйн хөнөөлт шавж голомттой, тархалт илэрч хортон шавж устгах, ажлыг 2024 оны 06 дугаар сарын 18 -ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01 -ны хооронд зохион байгуулж байгаа тул энэ хугацаанд голомт бүхий газарт хүн мал, тэжээвэр амьтан нэвтрүүлэхгүй хорио цээр тогтоосугай.

2. Хорио цээр тогтоосон хугацаанд ард иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг 3 дугаар багийн Засаг дарга (Л.Батсайхан, 1 дүгээр багийн Засаг дарга Ц.Доржготов, 4 дүгээр багийн Засаг дарга, Д.Эрдэнэжаргал, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Хишигсайхан, Байгаль хамгаалагч Ч.Амаржаргал, Д.Чимэдбальдир) нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Энхбаяр, ЗДТГ-ын дарга Г. Нямханд) нарт даалгасугай.

ДАРГА А.МӨНХ-ЭРДЭНЭ